



НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2013 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

Тэмцээнд оролцуулах тухай

Нийслэлийн Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын гадаад харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот, ОХУ-ын Сургуулийн сагсан бөмбөгийн лиг “КЭС-Баскет” байгууллагын хооронд байгуулсан хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:


1. Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын ахлах мэргэжилтэн А.Болдмаа ахлагчтай өсвөрийн сагсан бөмбөгчдийн 25 хүний бүрэлдэхүүнтэй баг тамирчдыг ОХУ-ын Пермь хотод болох Сургуулийн сагсан бөмбөгийн лиг “Кэс Баскет” шигшээ тэмцээнд 2013 оны 03 дугаар сарын 29-нөөс 04 дүгээр сарын 11-ний өдрүүдэд оролцуулсугай.

2. Тэмцээнд оролцох баг тамирчдын зардлыг хавсралтаар баталсугай.

3. Тэмцээнд оролцоход шаардагдах нийт 12.186.250 /арван хоёр сая нэг зуун наян зургаан мянга хоёр зуун тавь/ төгрөгийг Биеийн тамир, спортын орон нутгийн төсвөөс 8.000.000 төгрөг, төвлөрсөн арга хэмжээний зардлаас 4.186.250 төгрөгийг тус тус гаргахыг нягтлан бодогч Ж.Цэдэнсодномд зөвшөөрсүгэй.

4. Тэмцээнд оролцох бэлтгэл ажлыг хангаж, баг тамирчдыг оролцуулахыг ахлах мэргэжилтэн А.Болдмаад үүрэг болгосугай.

ДАРГА



Ж. ГАНБОЛД

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын
2013 оны ... дугаар ... сарын ...-ны өдрийн
... дугаар тушаалын хавсралт



Тэмцээнд оролцох тамирчдын зардлын төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн
1.	Галт тэрэгний зардал: Улаанбаатар – Пермь: 206450 ₮ x 25 хүн = 5.161.250 Пермь – Эрхүү: 3500 рубль x 25 хүн = 87500 рубль x 46 = 4.025.000 Эрхүү – Улаанбаатар: 120000 ₮ x 25 хүн = 3.000.000	12.186.250 төг
	ДҮН:	12.186.250 төг